



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/573

Булган сум

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2 дахь заалт, 19.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орхон сумын “Орхон-1” нэртэй хүрмэн чулууны (базальт) ордын 72.23 гектар талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг хавсралт хүснэгтийн дагуу энэхүү захирамж гарсан өдрөөс эхлэн 15 жилийн хугацаатайгаар “Хөх хайрга” ХХК-д олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Хөх хайрга” ХХК (П.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга), Байгаль орчны газар (А.Гантөмөр), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Татварын газар (Д.Лхагвасүрэн), Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/112 дугаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны ний өдрийн А/573 дугаар/дүгээр захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЖ БУЙ  
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

№	Хуулийн этгээдийн нэр	Ашиглалт хийх газрын нэр	Ашиглалтын талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Талбайн байршил						
					№	уртраг			өргөрөг		
						град	мин	сек	град	мин	сек
1	"Хөх хайрга" ХХК	Орхон "Орхон-1"	72.23	0	1	103	34	0	48	40	28
					2	103	33	40.84	48	40	28
					3	103	33	40.84	48	40	0
					4	103	34	0	48	40	0